



ЯАРАЛТАЙ

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035

Утас/Факс: (976-11) 32-71-99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022. 07. 20 № 03/3730

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Москва хотын Засгийн газар хооронд Хамтын ажиллагааны хөтөлбөрийг шинэчлэн байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Москва хотын Засгийн газраас ирүүлсэн Хамтын ажиллагааны хөтөлбөрийн төслийг орчуулгын хамт хавсралтаар хүргүүлж байна.

Иймд танай байгууллагаас тус хөтөлбөрт тусгах саналыг 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 10. хуудастай.

ДАРГА



Т.ОЮУНЧИМЭГ

Албан бус орчуулга
(2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар)

**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН МОСКВА ХОТЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улс, Оросын Холбооны Улсын нийслэл Улаанбаатар, Москва хотуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэд хоорондын нөхөрлөлийг бэхжүүлэх, улмаар хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хөгжилд нийслэл хотуудын зүгээс оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Оросын Холбооны Улсын Москва хотын Засгийн газар (цаашид “Талууд” гэх) энэхүү Хамтын ажиллагааны хөтөлбөрт гарын үсэг зурахаар тохиролцов.

Хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл

- 1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр :**
 - Талууд олон улсын чанартай арга хэмжээг хамтран зохион байгуулах, харилцан туршлага судлах замаар харилцаа холбоог тогтмолжуулах;
 - Талууд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр зохион байгуулагдаж буй үзэсгэлэн, яармаг, олон улсын арга хэмжээнд оролцож, харилцан туршлага солилцож, хамтын ажиллагааг бэхжүүлэх;
 - Талууд тэргүүлэх ач холбогдол бүхий эдийн засаг, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд харилцан туршлага солилцож, дэмжлэг үзүүлэх зэрэг болно.
- 2. Зам тээвэр, дэд бүтцийн хамтын ажиллагааны чиглэлээр:**
 - Талууд нийтийн тээврийн үйлчилгээ, замын хөдөлгөөний удирдлага, зохицуулалт, зам, тээврийн дэд бүтцийг сайжруулах;
 - Талууд цахилгаан тээврийн хэрэгслийг нийтийн тээвэрт нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, ухаалаг тээврийн тогтолцоонд компьютерийн загварчлалыг ашиглах;
 - Талууд авто зогсоолын ухаалаг тогтолцоог нэвтрүүлэх;
 - Талууд нийтийн тээвэр, авто зогсоол, дамжин зорчих хөдөлгөөний урсгал, маршрутыг сайжруулах;
 - Талууд нийтийн тээврийн салбарын холбогдох байгууллага, аж аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 3. Хот байгуулалт, хотын дэд бүтцийн чиглэлээр: :**
 - Талууд хотын байгуулалтын чиглэлээр туршлага судалж, хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - Талууд хот байгуулалт, хотын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр туршлага солилцох;
 - Талууд хотыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр туршлага солилцох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- 4. Хот тохижилтыг хөгжүүлэх чиглэлээр:**
 - Талууд хотын орон зайг тохижуулж, цэцэрлэгжүүлэх чиглэлээр ногоон байгууламжийг бий болгох таатай нөхцөлийг бүрдүүлэх;
 - Талууд хотын орчныг сайжруулах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн талбайг сэргээн засварлах төслүүдийг хэрэгжүүлэх;
- 5. Бизнес эрхлэлт, худалдаа, үйлчилгээний хөгжлийг дэмжих чиглэлээр**
 - Талууд барилга барих тусгай зөвшөөрөл, лиценз олгох чиглэлээр мэдээлэл солилцох, харилцан туршлага судлах;
 - Талууд худалдаа үйлчилгээний салбарын орчин үеийн ололт амжилтыг танилцуулах зорилгоор төрөлжсөн үзэсгэлэн, яармаг, хурал зохион байгуулах тухай мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлнэ.
- 6. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр :**

- Талууд иргэд төрийн үйлчилгээ авах болон төрийн байгууллагуудын олон нийттэй харилцах хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцох;
 - Талууд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төлөөлөгчдийн харилцан айлчлуулж, туршлага судлахад дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх,;
 - Талууд иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах, харилцан туршлага солилцох;
 - Талууд Улаанбаатар Москва хотуудын холбогдох байгууллагуудаас зохион байгуулдаг мэдээллийн технологийн чиглэлээр туршлага солилцох хамтарсан хурал, сургалт семинар, ажлын уулзалтад оролцоход дэмжлэг үзүүлэх.
- 7. Аж үйлдвэрийн хөгжил, инновацын чиглэлээр :**
- Талууд хотуудын нутаг дэвсгэрт өндөр технологийн аж үйлдвэрийг парк байгуулах чиглэлээр мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- 8. Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:**
- Талууд Улаанбаатар, Москва хотуудын боловсролын байгууллагуудын хооронд харилцан төлөөлөгч айлчлуулахад дэмжлэг үзүүлэх;
 - Талууд нийслэл Улаанбаатар хотын орос хэлний багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх дамжааг байгуулах чиглэлээр хоёр талт хамтын ажиллагаа явуулах;
 - Талууд сурагчдын боловсрол, хүмүүжилд боловсролын шинэ технологи, сургалтын хөтөлбөр боловсруулахад харилцан туршлага солилцох;
 - Талууд боловсролын чанарыг үнэлэх чиглэлээр харилцан туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх ;
 - Талууд Улаанбаатар, Москва хотуудын боловсролын байгууллагууд хооронд түншлэлийн харилцаа тогтооход дэмжлэг үзүүлнэ.
- 9. Эрүүл мэндийн чиглэлээр :**
- Талууд нарийн мэргэжлийн эмч (халдвар судлаач, хүүхдийн эмч, хүүхдийн халдварт өвчний эмч, теле анагаах ухааны чиглэлээр мэргэшсэн мэдээллийн технологийн мэргэжилтнүүд)-д зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтыг холбогдох эмнэлгийн байгууллагуудад зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
 - Талууд Улаанбаатар, Москва хотуудын эмнэлгийн байгууллагуудын хооронд төлөөлөгч харилцан айлчлуулахад дэмжлэг үзүүлэх;
 - Талууд эрүүл мэндийн салбарын сургалт, бага хурал, дугуй ширээний уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 10. Залуучуудын бодлогын хүрээнд :**
- Талууд залуу бизнес эрхлэгчдэд зориулсан арга хэмжээг хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
 - Талууд Улаанбаатар, Москва хотуудын залуучуудын дунд урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 11. Спортыг хөгжүүлэх чиглэлээр;**
- Улаанбаатар, Москва хотын спортын байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтоох;
 - Талуудын зохион байгуулж буй спортын арга хэмжээнд Улаанбаатар, Москва хотуудын тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх;
 - Талууд спортын арга хэмжээг цахим хэлбэрээр хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Ерөнхий үндэслэл

Энэхүү хөтөлбөр нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Талуудын аль нэг нь хөтөлбөрийн хүчинтэй хугацаа дусахаас гурваас доошгүй сарын өмнө энэхүү хөтөлбөрийг цуцлах хүсэлтэй байгаагаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй тохиолдолд энэхүү хөтөлбөрийн хугацаа 3 жилээр үргэлжлэн сунгагдана.

Талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр энэхүү хөтөлбөрт өөрчлөлт оруулж болно.

Энэхүү хөтөлбөр хэрэгжих бүх хугацаанд Талууд хоёр хотын түншлэлийн хэлхээ холбоог хөгжүүлэхэд чиглэсэн орон нутгийн засаг захиргаа, төрийн, арилжааны, олон нийтийн байгууллага, хувь хүмүүсийн хүчин чармайлтыг бүх талаар дэмжих болно.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлэлцүүлэг, уулзалт, бусад арга хэмжээг Талууд тохиролцон зөвшилцсөний дагуу хоёр улсын аль нэгэнд эсвэл өөр газарт зохион байгуулж болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой нарийвчилсан мэдээлэл, аргачлалыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр боловсруулж, батлах ёстой.

Энэхүү хамтын ажиллагааны хөтөлбөр нь Талуудын хүсэл зорилгыг тодорхойлсон учир хууль зүйн үүрэг хүлээхгүй болно.

2022 оны _____ “_____” _____ хотод монгол, орос хэлээр тус бүр 2 (хоёр) хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд нь ижил хүчинтэй болно.

**Монгол Улсын Нийслэлийн
Засаг даргын Тамгын газрыг
төлөөлж**

**Оросын Холбооны Улсын
Москва хотын Засгийн газрыг
төлөөлж**

**Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч
Д.Сумъяабазар**

**Москва хотын Захирагч
С.С. Собянин**

ПРОГРАММА СОТРУДНИЧЕСТВА

между



**Правительством Москвы
(Российская Федерация)**

и



**Мэрией города Улан-Батора
(Монголия)**

Правительство Москвы (Российская Федерация) и Мэрия города Улан-Батора (Монголия), далее именуемые «Стороны», с целью углубления дружбы и взаимопонимания между жителями двух городов, стремясь внести вклад в развитие двусторонних отношений между Российской Федерацией и Монголией, признавая, что расширение взаимовыгодного сотрудничества отвечает интересам населения и способствует экономическому развитию города Москвы и города Улан-Батора, договорились подписать настоящую Программу сотрудничества.

Приоритетные направления сотрудничества:

1. В области торгово-экономического сотрудничества Стороны будут способствовать:

- обмену опытом в сфере организации международного сотрудничества, а также в области укрепления связей между городами;
- обмену опытом в сфере работы с методическими материалами и нормативными правовыми актами Сторон в области поддержки и развития малого и среднего предпринимательства;
- обмену информацией о выставочно-ярмарочных и конгрессных мероприятиях, проводимых на территории Сторон;
- обмену опытом в вопросах формирования приоритетных инвестиционных проектов и привлечения иностранных инвестиций в экономики городов.

2. В области дорожно-транспортной инфраструктуры Стороны будут способствовать обмену опытом по следующим направлениям:

- управление и развитие общественного транспорта, обслуживание пассажиров городского транспорта, развитие дорожно-транспортной инфраструктуры, управление дорожным движением и работа городского наземного транспорта;
- внедрение электрического общественного транспорта и развитие электроинфраструктуры;
- использование интеллектуальной транспортной системы и компьютерного моделирования транспортных потоков;

- организация городской парковочной системы;
- создание транспортно-пересадочных узлов для маршрутного транспорта и перехватывающих парковок;
- установление прямых связей между организациями и предприятиями транспортной отрасли городов.

3. В области градостроительства и городской инфраструктуры Стороны будут способствовать:

- оказанию содействия в создании совместных программ и планов между городами по обмену опытом в области градостроительства;
- обмену опытом в области развития градостроительства и городской инфраструктуры;
- обмену опытом и осуществлению взаимодействия в вопросах разработки и реализации планов развития городов.

4. В области развития городского благоустройства территорий Стороны будут способствовать обмену опытом по следующим направлениям:

- создание благоприятных условий для озеленения и благоустройства городского пространства;
- в области благоустройства городской среды, проектов развития территорий и реконструкции городских общественных пространств.

5. В области содействия развитию бизнеса, торговли и услуг Стороны будут способствовать:

- обмену опытом в области информационного обмена в сфере выдачи лицензий и разрешительных документов на строительство;
- обмену информационными данными о проведении специализированных выставок, конкурсов, фестивалей, ярмарок и конференций с целью ознакомления с современными достижениями в сфере торговли и услуг.

6. В области телекоммуникаций и информационных технологий Стороны будут способствовать:

- обмену опытом в распространении информации о программах доступа населения к государственным услугам и взаимодействия государственных органов с населением;
- взаимному обмену делегациями с целью изучения опыта в области телекоммуникаций и информационных технологий;
- осуществлению взаимодействия и обмену информационным опытом в области улучшения государственных услуг для населения;
- оказанию содействия в вопросе участия в специализированных мероприятиях, а также в совместных конференциях, семинарах и рабочих встречах по обмену опытом в сфере информационных технологий, проводимых профильными структурами городского управления города Москвы и города Улан-Батора.

7. В области промышленного развития и инноваций Стороны будут способствовать:

- осуществлению взаимодействия и обмену информацией по размещению высокотехнологичных производств на территории городов;
- обмену опытом в вопросах поддержки малого и среднего бизнеса столицы, развития человеческого капитала, создания и развития инновационной инфраструктуры городов.

8. В области образования и науки Стороны будут способствовать:

- оказанию содействия в обмене делегациями между образовательными организациями города Москвы и города Улан-Батора;
- организации двустороннего взаимодействия по организации курсов повышения квалификации для учителей русского языка города Улан-Батора;
- обмену опытом в сфере разработки новых образовательных технологий, средств обучения в области цифровизации образования и воспитания обучающихся;

- оказанию взаимодействия и обмену опытом в сфере оценки качества образования;
- установлению партнерских отношений на уровне образовательных организаций города Москвы и города Улан-Батора.

9. В области здравоохранения Стороны будут способствовать:

- организации двустороннего взаимодействия по организации курсов повышения квалификации специалистов (инфекционистов, педиатров, врачей общей практики по вопросам детских инфекционных заболеваний, IT-специалистов в области телемедицины) в медицинских организациях систем здравоохранения городов Москвы и Улан-Батора;
- оказанию содействия в обмене делегациями между медицинскими организациями городов Москвы и Улан-Батора;
- оказанию содействия в организации мастер-классов, конференций и круглых столов по обучению работе в сфере здравоохранения.

10. В области молодежной политики Стороны будут способствовать:

- оказанию содействия в проведении совместных мероприятий, в частности для молодых предпринимателей;
- оказанию содействия в проведении молодежных мероприятий между жителями городов Москвы и Улан-Батора.

11. В области развития спорта Стороны будут способствовать обмену опытом по следующим направлениям:

- установлению прямых контактов между спортивными организациями Москвы и Улан-Батора;
- содействию участия спортсменов Москвы и Улан-Батора в спортивных мероприятиях, проводимых Сторонами;
- проведение онлайн совместных спортивных мероприятий.

Общие положения

Настоящая Программа вступает в силу с момента подписания Сторонами и действует в течение 3 лет. Действие настоящей Программы автоматически продлевается на 3 года, если ни одна из Сторон не направит другой Стороне письменного уведомления о своем намерении расторгнуть настоящую Программу не менее чем за 3 месяца до истечения срока ее действия.

Стороны по письменному согласию могут вносить изменения в настоящую Программу.

В течение всего периода действия настоящей Программы Стороны будут всячески поддерживать усилия своих органов местного самоуправления, государственных, коммерческих и общественных организаций, а также отдельных лиц, направленные на развитие партнерских связей между двумя городами.

Дискуссии, встречи или иные мероприятия, необходимые для выполнения настоящей Программы, могут быть организованы и проведены по согласованию Сторон в одной из двух стран либо в любом ином месте. Конкретные детали и методы реализации Программы должны разрабатываться и утверждаться при условии взаимного согласия Сторон.

Данная Программа сотрудничества фиксирует намерения Сторон и не будет иметь для них обязательной юридической силы.

Совершено в городе _____ «__» _____ 2022 года в четырех подлинных экземплярах на русском и монгольском языках, причем все тексты являются равно аутентичными.

**За Правительство Москвы
(Российская Федерация)**

**За Мэрию города Улан-Батора
(Монголия)**

**С.С. Собянин
Мэр Москвы**

**Д. Сумьяабазар
Мэр Улан-Батора**